

Регистрийн тугаар							
нэр				код			
Аймаг, нийслэл							
сум, дүүрэг							
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр							
Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл							

Өмчийн хэлбэрээр

	'100% төрийн	'100% хувийн	Холимог (төр- ийн өмчийн %)	
Шифр	1	2	3	..... %

Улсын тайлан маягт ШХИҮ-1

1. Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд 1, 4, 7, 10 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэл (дүүрэг) - ийн Статистикийн албанд
2. Аймаг, нийслэлийн статистикийн албад 1, 4, 7, 10 дугаар сарын 4-нд ҮСГ-т электрон шуудан, файл дамжуулах протокол /FTP/-оор
3. Шууд мэдээлдэг аж ахуйн нэгжүүд 1, 4, 7, 10 дугаар сарын 4-нд Үндэсний Статистикийн Газарт маягтаар

**ШУУДАН, ХОЛБОО, ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 200..ОНЫ ... Р УЛИРЛЫН ТАЙЛАН**

Үзүүлэлтүүд			Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Тайлант үеийн гүйцэтгэл
А			Б	1	2
<b>Үйлчилгээний нийт орлого</b>			мян.төг	1	
Үүнээс: хүн амаас орсон орлого			мян.төг	2	
Суурин телефон цэгийн тоо-бүгд			тоо	3	
Үүнээс: Айл өрхийн			тоо	4	
Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо - бүгд			тоо	5	
Үүнээс: Үндсэн хэрэглэгч			тоо	6	
Урьдчилсан төлбөрт карт эзэмшигч			тоо	7	
Хөдөлгөөнт утасгүй телефон (WLL)			тоо	8	
Үүнээс: айл өрхийн			тоо	9	
Сансрын холбооны хэрэглэгч			тоо	10	
Шугамын радио цэг			тоо	11	
Телевизорын тоо			тоо	12	
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч			тоо	13	
Интернэтийн үйлчилгээний цэг (Internet cafe)			тоо	14	
Интернэтийн үйлчилгээний цэгийн суудлын тоо			тоо	15	
Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо			тоо	16	
Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо			тоо	17	
Домейн нэр			тоо	18	
Вэб хуудас			тоо	19	
Байгууллагын компьютерийн тоо			тоо	20	
Таксафоны тоо			тоо	21	
Суурилуулсан АТС, ЭТС-ын тоо			тоо	22	
Цахилгаан мэдээ			мян.шир	23	
Үүнээс: - гарсан			мян.шир	24	
- дамжуулсан			мян.шир	25	
- орсон			мян.шир	26	
Шуудан, илгээмжийн төрөл	явуулсан	Бичиг захидал	мян.шир	27	
		Илгээмж	мян.шир	28	
		Хэвлэл	мян.шир	29	
	хүлээн авсан буюу хүргэсэн	Бичиг захидал	мян.шир	30	
Илгээмж		мян.шир	31		
Хэвлэл		мян.шир	32		
<b>Ажиллагчдын тоо</b>			тоо	33	
Үүнээс: эмэгтэй ажиллагчид			тоо	34	

Захирал (эзэн) .....

Ерөнхий (ахлах) нягтлан бодогч .....

Эдийн засагч .....

200..оны ...р сарын ...ны өдөр

## МАЯГТ ШХИҮ-1-ИЙГ НӨХӨХ ТОВЧ ЗААВАР

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 3.1”-ын дагуу Холбооны үйл ажиллагааны 64 дүгээр салбарын буюу Улсын шуудангийн үйл ажиллагаа, Улсын шуудангаас бусад зарлага элчийн үйл ажиллагаа, Яриа, дүрсийг дамжуулах, Мэдээ болон мэдээллийг кабелийн шугам (кабелийн телевиз), радио телевизийн шугам, релей ба сансрын антенны тусламжтай дамжуулах, Телефон утас, телеграф ба телефаксын холбоо, Радио ба телевизийн нэвтрүүлгийг дамжуулах, Сүлжээний засвар үйлчилгээг үзүүлэх, Интернетэд холбогдох, түүнийг ашиглах үйлчилгээ үзүүлэх, Олон нийтийн үйлчилгээний телефон утас (таксафон) зэрэг үйлчилгээ үзүүлдэг өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжүүд 1, 4, 7, 10 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн статистикийн албанд маягт ШХИҮ-1-ийг үзүүлэлтийн дагуу үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

**Аж ахуйн нэгж, байгууллагын төрлийг нөхөхдөө:** Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (БГБХ)-11, Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗГБХ)-12, Хувьцаат компани (ХК)-31, Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-32, Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-40, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ)-50, Төрийн бус байгууллага (ТББ)-70 гэсэн ангилалаар зохих шифрийг нөхнө.

Нийт үйлчилгээний орлого (мөр 1) гэдэгт холбоо, радио, телевиз, интернэт, шуудангийн үйл ажиллагаанаас орсон орлогыг оруулна. Хүн амаас орсон орлого (мөр 2) гэдэгт айл өрх, хувь хүмүүсээс орсон орлогыг оруулна. Нийт үйлчилгээний орлого нь хүн амаас орсон орлого, аж ахуйн нэгж байгууллагаас орсон орлогын нийлбэр байна. Нийт үйлчилгээний орлого болон үүнээс хүн амаас орсон орлогыг өссөн дүнгээр тавина.

Шугамын радио цэг, телевизорын тоо (мөр 11, 12) гэдэг нь тухайн радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээг хэрэглэж хураамж төлдөг хэрэглэгч цэгийн тоо юм.

Тухайн байгууллагад хамаарагдах интернет кафены тоог интернетийн үйлчилгээ үзүүлэгч цэг буюу интернет кафе гэсэн мөр 14-т нөхнө. Интернетийн үйлчилгээний цэгийн суудлын тоо гэдэг нь интернетийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор суурилуулагдсан, интернетэд холбогдсон компьютер бүхий суудлын тоо юм. Тухайн хугацаанд интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлсэн хэрэглэгчдийг давхардсан тоогоор, дүнгээр нь интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо гэсэн мөр (мөр 16)-нд нөхнө. Интернетийн үйлчилгээ үзүүлэгч цэгүүдийн хувьд интернетийн байнгын хэрэглэгчид гэсэн 17-р мөрийг бөглөхгүй.

Интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (ISP) интернетийн байнгын хэрэглэгчдийн тоо, домейн хаяг, вэб хуудасны тоо гэсэн үзүүлэлтүүд (мөр 17, 18, 19, 20)-ийг нөхнө.

**Интернэтийн байнгын хэрэглэгч** нь байгууллага ба хувь хүн байж болох бөгөөд ИҮБ-аас олгосон интернэт ашиглах эрхээр интернэтэд холбогдож байгаа нийт хүний тоог 17-р мөрөнд нөхнө.

**Домэйн нэр** (мөр 18) гэдэг нь интернэтэд аливаа субъектийг бусад субьектээс ялгахын тулд олгосон давтагдашгүй нэр юм.

**Вэб хуудасны тоо** (мөр 19) гэдэг нь тухайн улсын нутаг дэвсгэрт интернэтэд холбогдсон сервер компьютер дээрх вэб сайтын тоо юм.

Харилцаа холбоо, шуудан, интернэтийн үйлчилгээ эрхэлдэг бүх байгууллагууд өөрийн үйл ажиллагаандаа хэрэглэгдэж байгаа бүх компьютерийн тоог байгууллагын компьютерийн тоо гэсэн мөрөнд (мөр 20) нөхнө.

**Таксафоны тоо** (мөр 21) гэдэг нь зоос болон картаар ажилладаг нийтийн телефон цэг болон холбооны байгууллагад байрлах нийтийн телефон цэгийг багтаасан бүх төрлийн нийтийн төлбөрт телефон цэгийн тоо юм.

Шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд шуудан, илгээмжийн төрөл гэсэн хэсэг (мөр 27-32)-ийг бөглөнө. Явуулсан бичиг, захидал, илгээмж, хэвлэл гэдэг (мөр 27-29)-т гадаад улс орон, бусад аймаг, хот руу явуулсан бичиг, захидал, илгээмж хэвлэлийг оруулна. Харин хүлээн авсан буюу хүргэсэн гэдэг (мөр 30-32)-т гадаад улс орон, бусад аймаг хот, нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлэн хүлээн авагчдад нь хүлээлгэн өгсөн бичиг, захидал, илгээмж, хэвлэлийг оруулна.

Ажиллагчдын тоог (мөр 33, 34) тайлант хугацааны эцсийн байдлаар авна.

ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Утас: 312467.